



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.07.24 № 6-1/4890

танай _____-ны № _____-т

Гомдлын хариу

Танай байгууллагаас зарласан УУХҮЯ/201801003-01 дугаар бүхий “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын Багц-1-д оролцсон “Баяндөрвөлж” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55.2-т заасны дагуу холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

Үүнд:

“Баяндөрвөлж” ХХК нь Төрийн банкн дахь 259 дугаар бүхий тендерийн баталгаагаа 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдөр цуцалсан байх тул хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д “тендерийн баталгаа” гэж гэрээ байгуулах хүртэл, эсхүл тендерийн хүчинтэй байх хугацаа дуустал тендер хүчин төгөлдөр байх... гэж заасныг үндэслэн тухайн оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэх боломжгүй тул тендер шалгаруулалтыг цааш үргэлжлүүлэхийг үүгээр мэдэгдье.

Хувийг: “Баяндөрвөлж” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018.07.19 № 03/1943
танай 2018.07.06 -ны № 6-1/4507 -т

САНГИЙН ЯАМАНД

Танай 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 6-1/4507 тоот гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай албан бичгийн дагуу УУХҮЯ/201801003-01 дугаартай Багц-1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын их засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах /улсын хэмжээнд/ тендерийн холбогдох баримт бичгүүдийг жагсаалтын дагуу бэлтгэн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 34 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



08 1561



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018. 7. 6. № 61/4507
танай _____-ны № _____-т

**Гүйцэтгэгч сонгох ажиллагааг
түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай**

Танай яамнаас зарласан УУХҮЯ/201801003-01 дугаартай "Багц-1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын их засварын ажил /улсын хэмжээнд" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцсон "Баяндөрвөлж" ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол ирүүлээд байна.

Иймд хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу дээрх тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна. Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр
2. Тендерийн урилга /сонинд зарласан хуулбар/
3. Тендерийн баримт бичиг
4. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл
6. Захиалагчийн үнэлгээний хороо зохион байгуулсан шийдвэр
7. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар
8. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр
9. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг
10. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогчид хүргүүлснийг нотлох баримт
11. Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдэх
12. Холбогдох бусад баримт бичиг

Гомдлыг хянах явцад тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан арга хэмжээг авч ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.НАРАНЦОГТ